



БУДЫН БАТЖАРГАЛ

Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатын хурлын
гүйцэтгэх захиргааны дарга
1956-1959 он

Хуучин Түшээт хан аймгийн Эрдэнэ вангийн хошуу одоогийн Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт 1911 онд төржээ. Бага сургууль, Москва хотод КУТВ-ын сургууль, 1952 онд МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын дээд сургууль, 1956 онд хотын намын хорооны дэргэдэх Марксизм Ленинизмийн оройн их сургуульд тус тус суралцаж төгссөн.

1931-1933 онд сумын эвлэлийн үүрийн дарга, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн товчооны дарга, 1933-1936 онд Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотод ХЗЭ-ийн хорооны дарга, 1938-1943 онд Үйлдвэр, барилгын яаманд хэлтсийн дарга, 1943-1946 онд Улаанбаатар Төмөр замын захиргааны дарга, 1946-1956 онд Аж үйлдвэрийн комбинатын дарга,

1956-1959 онд Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны дарга, 1959-

1968 онд Аж үйлдвэрийн яамны орлогч сайд, Улсын барилга-эдийн засгийн комисст хариуцлагатай нарийн бичгийн дарга, Гадаадтай харилцах комплекс импорт нэгдлийн дарга, 1969-1973 онд Улаанбаатар хотын Ноос угаах үйлдвэрийн даргаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгожээ.

БНМАУ-ын Ардын Их Хурлыг сонгох гурав дахь удаагийн сонгуулиар АИХ-ын депутатаар, мөн МАХН-ын XI, XII, XIII их хуралд төлөөлөгчөөр сонгогдож байжээ.

Б.Батжаргалын ажлын амжилт бүтээлийг үнэлж "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-гоор хоёр удаа, "Алтан гадас" одон болон бусад медалиудаар шагнаж байжээ.